

ЭДҮГЭЭГИЙН МОНГОЛ УЛСЫН НУТАГТ БАЙСАН БУРХНЫ ШАШНЫ ХУРАЛ, НОМЫН ГАЗРУУД

З.Лонжид

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэлд эдүгээгийн Монгол улсын нутагт буддизм анх нэвтэрч эхэлсэн, түүний хүрээ, хийд сүм, дуган, дацан, аймаг, суварга зэрэг байгууламжуудын ялгаа, хүрээ хийдийн өмч буюу жасын үйл ажиллагааны тухай хураангуй өгүүллээ.

Түлхүүр үг: Чингис, Хөхэчү, Өгэдэй, Хубилай, Түмэнзасагт, Лигдэн, Занабазар, Түддэн, Позднеев, Майский, Эрдэнэ-зуу, Майдарын сүм, Арьяабалын сүм, Ямандаг бурхан, шар, улаан, хөхийн шашин, Ярнай, Ямпай.

Эдүгээгийн Монгол Улсын нутаг дэвсгэрт бурхны шашин дэлгэрэн хөгжсөн хугацааг Хүннү улсын үеэс эхтэй хэмээн түүхчдийн бүтээлд тэмдэглэсэн байдаг. Гэвч лавтай мэдээгээр бол 745-840 онд оршин тогтнож байсан Уйгурын хаант улсын төр 763 оны орчмоос өвөг дээдсийнхээ онгоныг тахьдаг уламжлалаа орхиж манай эриний III зууны үед Персийн Мани /Mani/ гэдэг хүн Зоро Астер /Zoroaster/-ын хоёр эшит онолд тулгуурлан христосын шашин, буддын шашин, гностиг /Gnosticism/-ийн онолуудаас авч үндэслэсэн Манийн шашин буюу зороастеризмыг шүтэж байгаад төдий л удалгүй бурхны шашныг дээдлэн сүсэглэх болсон тэр үеэс хойш Монгол нутагт буддизм буюу бурхны шашин дэлгэрч өргөн олныг хамарчээ.

Гэвч түүнээс хойш энэхүү шашин нь Киргизийн үед бага зэрэг буурч харин Хятан улсын сурвалжтангууд будда хүнз, даосын шашны аль алийг дамжиж байв. Их Монгол Улсын үед уламжлалт бөөгийн шашнаа дээдэлж биширч байсан боловч бурхны шашин, лал, загалмайтны шашныг ямар нэгэн байдлаар дор үзэх буюу ялгаварлан гадуурхсангүй хэн хүн хүссэн шашнаа чөлөөтэй шүтэх эрхтэй байлаа.

Чингис хааны үед Монголын төр бөөгийн шашныг бусад шашнаас илүүтэй дээдэлж байсныг зарим хүн тухайлбал Хонхтон Мэнлигийн долоон хөвгүүний дундах Хөхэчү буюу Див тэнгэр эцэг, ах дүү нартайгаа үгсэн хуйвалдаж улс төрд харш ноцтой хэрэг удаа дараа өдүүлэх болсон учир эзэн хааны зарлигаар түүний амийг хороосноос хойш Монголын төр бөөгийн шашныг бусад шашнаас илүү онцгойлохоо үндсэндээ зогсож бүх шашинд төрөөс адил тэгш хандаж байсан гэж судлаачид үздэг билээ.

Гэвч Өгэдэй хааны үед байгуулсан Хархорин хотын туурийг шинжилсэн археологчдын нотолж байгаагаар бол бурхны шашны нэлээд том хэмжээний нэг бус сүм буюу дуган тус хотод байжээ. Энэ нь ямар ч байсан 1229 оноос буюу Өгэдэйн хаанчлалаас эхлээд тус хотод бурхны шашны зан үйл гүйцэтгэхэд зориулсан тусгай барилга байгууламж барьсныг илэрхий нотолж байна. Ийнхүү Өгэдэй хааны үед Монголын нийслэл болсон тус хотод бурхны шашны зориулалтын барилга байсан нь тухайн цагт бөө болон бусад шашныг огт шүтэхгүй байсны баталгаа бус боловч монголын төр бурхны шашныг бусад шашнаас илүү дотнолон дээдэлж байсны нотолгоо ч бас биш билээ.

Харин Их Монгол Улсын үед бурхны шашны том барилга байгууламж Хархоринд байсан нь ямар ч маргаангүйг гэрчилж байна. Өөрөөр хэлбэл, Өгэдэй хааны үеэс эдүгээгийн Монгол Улсын төв нутагт сүсэгтэн олны тусын тулд шашны зориулалттай тусгай барилга барьж босгосон нь бодитойг эргэлзээгүй нотолж байгаа юм. Гэхдээ Өгэдэй хаан уугуул бөөгийн шашинд итгэж аливаа зовлон зүдгүүр тохиолдсон нөхцөлд бөө нарт хандаж мэргэ төлөг үзүүлж засал хийлгэсээр байсан тухай сурвалж зохиолд дурдсан байдаг. Харин Монголын төрийн их сэнтийд багагүй маргаан сөргөлдөөнийг туулж байж заларсан Хубилай хаан өвөг

сэнтййд багагүй маргаан сөргөлдөөнийг туулж байж заларсан Хубилай хаан өвөг эцэг Чингисээс уламжилж ирсэн төрийн бодлогын хэд хэдэн чиглэлийг огцом ба зуугуухан байдлаар халж шинэчилсэн билээ. Тухайлбал тэрбээр хаан ширээнд суусан жилээ 1260 онд зарлиг буулгаж Түвэдийн бурхны шашны Сажияа аймгийн тавдугаар үеийн өвөг багш таван ухаанд гоц нэвтэрсэн хорин есөн настай лам Пагва /Phagspa/-г улсын багшаар өргөмжилж хас эрдэнэ тамга шагнаж бүх улсын бурхны шашин ба түвд орны хамаг хэргийг түүнд эрхлүүлжээ. Чухам энэ үеэс Монголын төр бурхны шашныг төрийн шүтээн болгосон байна. Гэвч монголын хүн амын цөөнгүй хэсэг нь эртний уламжлалт бөөгийн шашнаасаа бүрмөсөн ангижирсангүй үргэлжлүүлэн шүтсээр XVI зууны үед хүрсэн билээ. Өөрөөр хэлбэл 1260 оноос эхлэн эзэн хааны зарлиг төрийн цааз хуулиар бурхны шашныг улсын гол шүтээн болгосон боловч бөөгийн шашин монголчуудын итгэл бишрэлээс бүрмөсөн арилаагүйгээр үл барам зарим ихэс дээдэс бурхны шашныг үл тэвчин зөвхөн бөөгийн шашныг илүү дотночлон шүтсээр байсан бол зарим ноёд түшмэд Хубилай хааны үеэс өргөн цартай дэлгэрүүлж эхэлсэн бурхны шашнаа бүхнээс дээгүүрт үзэж бөөгийн шашныг аль болохоор шахан түрэх бодлого баримталж түүнийгээ хэрхэн хэрэгжүүлэх арга зам эрэлхийлэх болсон аж. Чухам ийм чиг хандлагатай эрх мэдэлтнүүдийн нэг бол Монголын их хаан Түмэн билээ. Тэрбээр 1576 онд Түвдээс улааны шашны нэр алдартай зарим лам нарыг залж ирүүлэн тэдэнтэй багш шавийн барилдлага тогтоож зургаан түмэн Монгол даяар бурхны шашны улааны чиглэлийг дэлгэрүүлэх зарлиг буулгаж байлаа. Гэвч Монголын нилээд олон аймаг гэлүмбагийн шашныг шүтсэн учир улааны шашин нь цахар аймгаас төдий л хальж чадаагүй аж.

Түмэн засагт хаантай ураг садангийн холбоотой Монголын баруун гурван түмний нэг Түмэдийн Алтангэгээн хан хэмээн олноо алдаршсан Ананд 1578 онд Хөх нуурын Чавчаал буюу Цав цайл хэмээх газар "Тэгчинчойнхорлин" хэмээх нэртэй сүм байгуулж /С.Пүрэвжав.1978.31/ гэлүмба бүлгийн шашны тэргүүлэгч гуравдугаар их ламтан Содномжамцыг урин залж ирүүлээд түүнд мөргөж номын абшиг хүртэж ихэд бишрэн тэрхүү ламтанд "Богд хамаг бүгдийг айлдагч Очирдар-а Далай лам" цол хүртээсэн бөгөөд үүнийх нь хариуд Далай ламтнаас Алтангэгээн ханд "Мянган алтан хүрдийг эргүүлэгч чагирварид сэцэн хан" цол шагнажээ. Ингэж бурхны шашны гэлүмба бүлгийн тэргүүн Монгол нутагт морилон саатаж ихэс дээдэст бурхны сургаал ном айлдсанаар бурхны шашин монголд урьд өмнөхөөсөө илүү дэлгэрэх шинэ үе эхэлжээ. Алтангэгээн хан Далай ламтанд бараалхан номын абшиг хүртсэнийхээ дараа жил буюу 1579 онд "Их зуу" /Dazhoo temple/ сүмийг Хөх хотод бүтээлгэсэн нь монголчууд бурхны шашин шүтэх нэг том төв болсон юм. Жич тэмдэглэхэд шашин судлаач түүхчдийн зарим нь Их зуу-г байгуулах санаачлага 1554 онд анх гарсан гэж үздэг. 1582 онд Алтангэгээн ханыг таалал болоход түүний хөвгүүн Сэнгэдүүрэнгийн заллагаар Далай ламтан дахин Монголд морилж Алтангэгээн ханы хойтын буян хураах ном айлдсанаар монголчууд бурхны шашныг улам бүр дээдлэн шүтэх болжээ.

Ингэж бурхны шашин Монгол газар дахин нэвтэрч түгэн дэлгэрэхэд Алтангэгээн хан тэргүүлэх үүрэг гүйцэтгэсэн бөгөөд түүний бүтээлгэсэн Их зуу сүм эдүгээ БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны нийслэл-Хөх хотод бүрэн бүтнээрээ байна. Энэхүү Их зуу бол бурхны шашны шарын буюу гэлүмба бүлгийн сургаал номлолыг монголчуудад түгээж эхлэхэд бүтээсэн анхны шүтээн учир Монгол төрийн үе үеийн хаад Түмэн засагт хаан /1539-1593/, Буянсэцэн хаан /1555-1603/, Лигдэн хутагт хаан /1592-1634/ болон Манж Дайчин улсын бүх хаад тэрхүү сүмийг түүх шашны их өв дурсгал хэмээн онцгой анхаарч байв. Тухайлбал 1636 онд Монголын өмнөд хэсэг Манжид дагаар орсны дараахан буюу Абахай хун тайж, 1698 онд Энх-Амгалан хаан нарын зарлигаар "Аугаа энэрэнгүй сүм",

“Цаглашгүй сүм” хэмээн дээдлэн нэрлэж засаж сэлбэж сүсэгтэн олны их хөлийн газар болгосон боловч улирах цагийн уртад элэгдэж хуучирсныг 1980 онд Өвөр Монголын өөртөө засах орны Засгийн газраас ихээхэн зардал төсөв гаргаж сэргээн засварласан нь сүсэгтнүүд, жуулчид хийгээд хэн бүхний заавал очдог шашны дурсгалт төв болжээ.

Алтангэгээн ханыг таалал болсноос хойшхи арван жилд Түвд, Монголын шашин улс төрийн харилцаа гүнзгийрүүлэхэд зохих анхаарал тавьсан хүн бол Түмэн засагт хаан юм. Түүний төрийн таван их сайдын нэг Цахарын Намудай хун тайж 1587 онд Түвд газар одож Далай ламтанд мөргөж алт, мөнгө эд агуурс тэмээ, адуу олныг өргөж *“манай цахар түмэн Богд ламыг шашны үйлсийн төлөөнөө Монголд морилохыг айлтгах элч ирүүлбэл соёрхох эсэхийг”* лавлан болгоосонд тэрбээр энэ жилдээ багтаж элч ирүүлбэл очиж болох юм. Харин дараа жил уривал над зав чөлөө байхгүй хэмээн хариу айлдсаны дагууд Гэтэл Түмэн засагт хаан Хэшигтний Түмэн тайж, Хэмчигүүдийн Бага Дархан ноён тэргүүтэй элч нарыг илгээсэн байна. Гэтэл яг тэр үед Мин улсын Вань-Ли хаан мөн гурван их ноён илгээж, Далай ламтныг урьж залсан байв. Ингэж Монгол, Мингийн хоёр хааны элч нар нэгэн зэрэг Далай ламтныг урин залсан боловч тэрбээр аль ч улсад нь очих боломжгүйгээ айлдаад таалал барьсан тухай Саган сэцэн тэмдэглэн үлдээжээ. Хэдийвээр Түмэн засагт хаан Далай ламтныг нутагтаа залж хараахан амжаагүй боловч бүх монголчууд ялангуяа монголын ихэс дээдэс бурхны шашинд тун нааштай хандаж байгааг тухайн үеийн Түвдийн эрх мэдэлтнүүдэд нотлон үзүүлж чадсан нь хожим 1602 онд Далай ламтны дөрөвдүгээр дүрээр монгол хүн буюу Алтангэгээн ханы ач Цэнгэлжалбын Ёндонжамцыг тодроход ихээхэн нөлөө түлхэц болсныг үгүйсгэх аргагүй.

Хубилай хааны үеэс эхэлсэн шашин, төрийг тэгшээр мандуулах бодлогыг тууштай үргэлжлүүлсэн ихэс дээдсийн нэг бол Ар Халхын галзуу тайж хэмээн алдаршсан Гэрсэнз Жалайр хун тайжийн ач Абатай 1581 онд /зарим түүхч 1587 он гэдэг нь ташаа мэт/ Хөх хотод саатан морилж байсан Далай лам Содномжамцад биечлэн бараалхаж, булган бүрээстэй гэр хэдэн түмэн мал адгуус өргөж бурхны шашны гэлүмба бүлгийг дээдлэн шүтэх соёрхол айлтгахад Далай ламтан түүнийг хөхиүлэн сайшааж, өөрийн бурхдын дотроос аль дуртайгаа шилж ав хэмээхэд тэрбээр Очирваань бурхныг сонгосон байна. Иймээс Далай ламтан түүнд Очирой хан цол шагнаж, түүнээс хойш Халхын Очиройбат хан хэмээн алдаршсан аж. Абатай хан Далай ламтанд бараалхан золгосноосоо хойш бурхны шашинд чин үнэнчээр сүсэглэж Халх даяарт бурхны номлол сургаал түгээн дэлгэрүүлэх үйлсэд үнэн сэтгэлээсээ хичээж Шигимунийн мэндэлсний 2546 жил, Чингис хааны мэндэлсний 464 жил¹ Зонхаба-ын мэндэлсний 229 жилийн ойг тохиолдуулан 1586 оноос эхлэн Хархорины туурин дээр Эрдэнэ зуу хийдийг байгуулжээ. /Содбилиг.1996.42/. Энэ бол өмнө дурдсан Түмэдийн Алтангэгээн ханы үүсгэн цогцлоосон Хөх хотын “Их зуу” сүмийн дараа Монгол нутагт байгуулсан шарын шашны том хийд билээ. Иймээс ч тус хийдэд 420 гаруй жилийн турш бурхны шашинд сүсэглэдэг өргөн олны эргэл мөргөл тасралтгүй үргэлжилсээр ирлээ. Гэвч 1680-аад оны сүүлчээр Халх, Ойрадын хямралын үед тус хийд дайн самууны хөлд нэрвэгдэж, зарим бурхан шүтээнээ алдаж эвдүүлсэн боловч Манж Дайчин улс, Хаант Монгол улсын үед буюу 1691-1919 онд зөвхөн Халх төдийгүй Ойрад, Халимаг, Өвөр Монгол, Барга, Цахар, Дээд Монголын өргөн түмний итгэл бишрэлийг татсан шашны том төвүүдийн нэг байлаа. Харин 1930-аад оны сүүлчээс эхлэн Монголын төрөөс шашны талаар баримталсан бодлого хэсэг

¹ Түүхч Содбилэг 1996 онд Өвөр Монголд хэвлүүлсэн “Шашны толь” хэмээх бүтээлийнхээ 42 дахь талд ингэж бичсэн нь Чингис хааныг 1162 онд мэндэлсэн гэж үздэгтэй тохирохгүй байгаа юм.

хугацаанд гажуудсаны улмаас тус хийд зөвхөн түүх, шашин, соёл, уран барилгын дурсгалт газар болж байгаад өнгөрсөн зууны сүүлчээс эхлэн шашны хурал номоо сэргээж тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

XVI зууны сүүлч XVII зууны эхэн үед Монголын төрийг тэргүүлж байсан Буян арван жил /1593-1603 он/ хаан эцэг Түмэн засагтынхаа бодлогыг үргэлжлүүлж өргөн олонд Буян сэцэн хаан хэмээн алдаршиж байсныг судлаачид бүтээл туурвилдаа тэмдэглэсэн билээ. Гэвч тэрбээр шашин номын үйлс түгээн дэлгэрүүлэх зорилгоор чухам ямар зүйл сэдэж хэрэгжүүлснийг түүхчид эдүгээ хүртэл төдий л судлаагүй байна. 1604 оноос эхлэн гучин жил Монголын эзэн хааны ширээнд заларсан Лигдэн хутагтын үед бурхны шашин монголчуудын дунд урьд урьдаас илүү хүчтэй түгэн дэлгэрэх маш зохистой нөхцөл бүрдсэн юм. Тухайлбал Дээрхийн гэгээнтний дөрөвдэх дүр Чингис эзний алтан урагт хувилж тодорсноос хойш монголчуудын итгэл бишрэл улам бүр гүнзгийрч янз бүрийн бурхан бүтээх, хандив өргөх нь олныг хамрах болжээ. Тухайлбал 1606 онд Алтан гэгээн хааны ач хүү Дайчин тайжийн хатан Мэчин хэмээгч хөрөнгө зардлыг нь гаргаж Хөх хотын баруунтаа орших Түмэд зүүн хошууны нутагт "Майдар зуу"-г бүтээлгэсэн байна /Содбилиг. 1996.216/. Эгэл харц иргэнээс эхлээд ихэс дээдсүүд хүртэлх нийт олны дунд шашныг улам бүр бишрэх болсон нь Лигдэн хутагт хаан шашныг дэмжихэд онцлон анхаарч байсантай ч бас холбоотой.

Лигдэн хаан бурхны шашныг дэмжих тууштай бодлого хэрэгжүүлэх болсон нь зохих учир шалтгаантай. Тухайлбал 1616 оноос эхлэн Зөрчиний бараг бүх аймгийг нэгтгэж Хойд Алтан улсыг байгуулан захирсан Нурхачи хаяа савлаж хил залгасан Монгол, Мин улсын аль алиныг өөртөө нэгтгэх эцнээ зорилго агуулж байлаа. Гэтэл тэр үед Монголын улс төрийн хямрал улам гүнзгийрч язгуур угсаатай ноёд эзэн хаандаа буюу төрдөө захирагдахгүй бие даасан байдалтай болохыг эрмэлзэж байсан билээ. Чухам ийм нөхцөлд монголын ихэс дээдэс шашин суртлаар ард иргэдээ сэнхрүүлж эв зетэй байхыг хичээх нь туйлын зөв байлаа.

Лигдэн хаан ширээ залгамжилсан жил 1604 онд дөрөвдүгээр дүрийн дээрхийн гэгээнтэн Түвдийн их ламтан Майдар хутагт Занангунгаанямбууг Монголын бурхны шашны хэргийг эрхлэх ширээт ламаар томилон Хөх хотод байнга суулгажээ. Лигдэн хаан тэрхүү Майдар хутагтаас "гүн нарийн хөлгөний абшиг аван" бурхны шашинд нэн хүндэтгэлтэй ханддагаа баталсан байна. Ингэж дээрхийн гэгээнтэн уугуул Монголдоо бурхны шашин дэлгэрүүлэхэд онцгой анхаарах болсон аж.

Тэр үед Түвдэд бурхны шашны шар, улаан хоёр бүлгийнхэн ихээхэн сөргөлдөх болсны уршгаар 1616 онд Түвдийн Дэсрид Занбо хаан тусгай хүн зарж дөрөвдүгээр дүрийн Далай ламтныг хороолгосон гэх бөгөөд тэр үеэс эхлэн Түвдийн дотоод хямрал нэн хурцдаж, шашны хоёр бүлгийнхний сөргөлдөөн нь дайсангал болж хожмоо Түвдийн төрийн эрх харийнхны эрхшээлд ороход хүргэсэн юм. Лигдэн хутагт хаан улааны бүлгийнхнээс нилээд болгоомжлон эцэстээ шарын бүлгийг дэмжихээ азнах болжээ. Лигдэн хутагт хаан хэдийгээр Дээрхийн гэгээнтэнд биечлэн бараалхаж номын абшиг хүртээгүй боловч Монгол орноо шашин дэлгэрүүлэхээр түүнийг анх сэдсэн их үйлсийг улам гүнзгийрүүлэхийг насан туршдаа хичээжээ.

Судлаачдын бүтээлээс үзвэл эзэн хаан Лигдэнгээс эхлээд бүх монголчууд Дээрхийн гэгээнтнийг сэрүүн тунгалаг ахуйд нь бүхнээс илүү шүтэн дээдэлж байсан учир түүнийг 1616 онд жанч халсны дараа шарилыг нь Халхын засаг ноён Чихур/?/ Түмэдийн нэг тайжтай хоёул хуваан авч Чихур ноён авсан хэсгээ мөнгөн суварганд агуулж Дээрхийн гэгээнтний анх шавилж байсан Бэрээбэн хийдийн Гандан

повронд залжээ. Харин Түмэд тайж авсан зүйлээс хэрхсэн нь тодорхойгүй байна /П.К.Козлов. *Тибет...* М.2004.64/.

Дөрөвдүгээр Далай ламтныг 1616 онд хорин найман сүүдэртэйд нь “Дэсэрид Занба хаан хүн зарж хороолгов” (Содбилэг 1996, 343) гэсэн яриа олны дунд тархсанаас хойш Лигдэн хутагт хаан Түвдийн шашны хоёр урсгалын аль алинд нь болгоомжтой хандах болжээ. Гэвч 1618 оноос монголын зүүн захын Цахар зэрэг аймгуудад шарын шашин хурдацтай тархаж буйд таагүй хандах болсон Түвдийн улааны шашныхан өөрсөддөө дэмжлэг олох зорилгоор Шарав хутагтыг Монголд томилон очуулахад Лигдэн хаан тэрхүү хутагттай Цагаан хотод уулзаж эрдэм увдисыг нь биширч, түүнээс “гүн Очирт хөлөг”, очир эрихийн абшиг авч түүнд “Очир дара хутагт” цол шагнаж улсын багшаар өргөмжлөв /Дарма гүүш 2006.87/.

Лигдэн хутагт өөрийг нь гүн хүндэтгэлтэй угтаж улсын багшаар өргөмжилсөнд ихэд талархсан Шарав хутагт нэр хүндээ улам дээшлүүлэх, улааны шашны идэвхтэй дэмжигчидтэй байхын тулд Шизү хаан Хубилайн зарлигаар улсын багш Пагва-ын мянган лан шижир алтаар цутгуулсан Махагал бурхныг Үтайгаас залж Лигдэн хаанд өргөжээ. Лигдэн хаан ч үүнд биширч “Алтан уснирт /дээвэрт/ цагаан сүм байгуулж тэрхүү махагалыг түүн дээр тавьж тахив” /Монгол үндэстэн...1995.1040/.

Ингэж XVII зууны эхээр Монголд бурханы шашин нилээд өргөн дэлгэрснээр төв суурин газруудад бурхны сүм, хурлын дуган байгуулах нь улам нэмэгдэж байлаа. Үүнээс гадна шашны онол сургаалын хөлгөн их туурвилуудыг монголчлох хэвлэх талаар ч анхаарч бодитой ажил хэрэгжүүлж байлаа. Тухайлбал анх 1602-1609 онд Монголын Намудай сэцэн хан, Жүнхэн хатан, Соном тайж нарын санаачлагаар тухайн үеийн хамгийн шилдэг гүүш нарыг цуглуулж Ширээт гүүш, цорж Аюуш, Ананд Манзушир нарын удирдлагаар 108 боть Ганжуурыг орчуулж эхэлсэн боловч эцэслэн дуусаагүй байсныг Лигдэн хааны зарлигаар 1628-1629 онд Гүнгаа-Одсэр мэргэн бандида хийгээд Ананда Шрибадра тэргүүтэй гучин гурван их гүүш нэрт эрдэмтднийг цуглуулж Ганжуурын бүх ботийг бүрэн төгс орчуулгаж хөх дэвсгэр дээр алтаар бичүүлжээ.

Ингэж Лигдэн хутагт хааны зарлигаар дэлхий дахинаа алдартай бурхны шашны их хөлгөн туурвил Ганжуурыг бүрэн монголчилж алтан үсгээр хэвлүүлсэн нь монголчууд дэлхийн соёлын түүхэнд оруулсан томоохон хувь нэмэр гэдгийг тэмдэглэх ёстой. Лигдэн хааны гурван эрдэнэ хэмээн үе үеийн түүхчдийн бүтээлд тэмдэглэсэн Монгол төрийн алтан тамга, алтан махагала бурхан, алтан Ганжуур бол XVII зууны үед монголын төрөөс шашны талаар маш өргөн цар хүрээтэй алсыг харсан бодлого хэрэгжүүлсний нотолгоо болж байна. Өөрөөр хэлбэл, хэдэн зууны турш монгол хаадын мутартаа атгаж байсан төрийн тамга, Юань улсын үед бүтээсэн махагала бурхан, их хөлгөний 108 боть судрын орчуулга зэргийг Лигдэн хутагт хаан бүхнээс илүү дээдэлж шүтэж байсан нь Хубилай хааны үеэс анх эхэлсэн хос ёсны сургаалыг Монголын сүүлчийн хаад сэргээн хэрэгжүүлж чадсаныг маргаангүй нотолж байна.

Ганжуурын бүх ботийг орчуулан хэвлэж түгээсэн тэр үеэс эхэлж, түүний 108 боть хөлгөн судрыг тусгай сүмд байрлуулан залж шүтэх болсноор монгол нутгийн олон газарт “Ганжуур сүм” хэмээх нэгэн шинэ төрлийн сүм бий болсны сацуу хошуу аймгийнхаа хил хязгаарыг тойрч Ганжуурын гороо эргэл хийх ёслол бас шинээр нэмэгджээ. Үүний сацуу Ганжуурын гороо хийж ахуйдаа түр саатах хоноглох газруудыг зориуд бэлтгэж, тусгай овоо босгон тэмдэглэх болсноор Ганжуурын овоо хэмээх мөн нэгэн шинэ зүйлийн овоо бий болсон гэдэг. Харин эдүгээгийн Монгол нутагт ганжуур овоо, ганжуур сүм чухам хаана хаана байсан нь ер тодорхойгүй болжээ.

Жич тэмдэглэхэд, Лигдэн хааныг таалал болсны дараа түүний "гурван эрдэнэ"-ийн хувь заяа хэрхсэн бэ гэдгийг нэхэн судлууштай. Бидний эргэцүүлэхэд Алтан ганжуур нь тухайн цагт барласан эхээрээ хадгалагдан үлдээгүй байж болно. Мөн алтан махагала бурхан ч улирах цагийн уртад үрэн таран болсон байхыг үгүйсгэх аргагүй. Харин төр, шашины их үйлсэд Лигдэн хутагт хааны байгуулсан гавьяа үеийн үед дурсагдахаар байх нь эргэлзээгүй билээ.

Дээр өгүүлснээ хураангуйлан дүгнэхэд XIII зуунд Хубилай хааны үеэс бурхны шашныг албан ёсоор Монгол төрийн шашин болгосныг 1368-1634 онд Монголын хаад хэвээр үргэлжлүүлсэн боловч улс төрийн хямралын уршгаар төрөөс шашны талаар баримтлах бодлого үе үе алдагдаж байв. Харин Түмэн засагт хаан Түмэдийн Алтангэгзэн хан нар шашны тухайд нилээд зөв бодлого хэрэгжүүлснийг Монголын хамгийн сүүлчийн хаан Лигдэн хутагт хэвээр үргэлжлүүлсэний үрээр алтан ургийн монгол хүн бурхны шашны тэргүүн Дээрхийн гэгээнтний шинэ дүрээр тодорсон байна. Тэр үеэс шашин төрийн хос ёсны сургаал идэвхтэй хэрэгжиж хэд хэдэн хүрээ, хийд, сүм байгуулж, шашны их хөлгөн судрыг монголчилж, бурхан шүтээн бүтээлгэн залсан байна.

Лигдэн хааны үед одоогийн Монгол нутагт бурхны шашны газрууд байгуулахад зохих үүрэг гүйцэтгэсэн хүн бол Халхын Цогт хунтайж билээ. Тэрбээр өөрийн эх Мади Тайхал хатны хамт хамаг амьтны тусын тулд буян санаж 1601-1617 онд Халдудын зүрхэн хэмээх уулын өвөрт /одоогийн Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг/ Номын их орон байгуулж, төв дунд нь Сэтгэшгүй "Чандмань" буюу Самъяа бухар хийд тэргүүтэй зургаан сүм барьж гурван цагийн хамаг бурхан-/улирсан цагийн Дивангар, эдүгээ цагийн Шигэмүни, ирээдүй цагийн Майдар/-ыг бодисадва наймаар хүрээлүүлэн залж, баруун талын их хийдэд нь Майдарын лагшинг байрлуулжээ. Мөн тэдгээр сүм хийдийн дотор Сандуй, Мижиддорж, ялж төгссөн Хээбазарын лагшинг босгож гол сүмийн зүүн урд өнцөгт хоёр сүм барьж Жанрайсиг, Дара-эх хоёрын хөрөг Доржжигжэдийн лагшинг байгуулсан байна.

Сүмийн дотор зарлигийн шүтээн босгож найман түмэн дөрвөн мянган номын цогцыг хамтад хураасан "Их юм"-ыг арванхоёр ботиор голлон зохиосон бурхны зарлигийг оршоосон байна. Энэ тухай уул хийдийн тус газар босгосон гэрэлт хөшөөнд чингэж дурдсанаас өөр ямар нэгэн сурвалж одоогоор олдохгүй байна. Тиймээс уг хийд чухам хэдүйгээс эхэлж хэдэн жилийн турш оршин тогтносон, ямар ямар бурхадтай, хэдэн лам хуврагтай байсан зэрэг нь ер тодорхойгүй. Харин уг хийдийн туурийг нутгийн ард иргэд Цогт хунтайжийн "цагаан байшин" хэмээн нэрийддэг. Цогт тайж 1630-аад оны эхээр Хөх нуурт очиж Лигдэн хутагт хаантай хамтарч Хойд Алтан улсын хоёрдахь хаан Абахайн эсрэг дайтахаар халхаас морилон одсон байна. Тэгэхдээ өөрийн байгуулсан хийдээ ер эзэнгүй орхиогүй байх. Гэвч Халх, Ойрадын дайны үед эвдэрч улмаар эзгүйрсэн байж магадгүй боловч чухам шалтгааныг нотлохуйц мэдээ сурвалж хомс учир судлаачид энэ талаар шинжилгээний бүтээл туурвихад түвэгтэй байна. Олон жил улиран ам дамжсан мэдээгээр бол Цогт хунтайж Хөх нуур луу морилох зам зуураа одоогийн Дундговь, Өмнөговийн залгаа нутаг Дундговь аймгийн Өлзийт сумын өмнө этгээдэд нэгэн бяцхан сүм байгуулан хурал хурж байжээ. Түүний үлдэц дөрвөн хана эдүгээ ч байх бөгөөд түүнийг тэр нутгийнхан "Чулуун сүм" хэмээн нэрлэдэг билээ.

Лигдэн хаанаас хойш бурхны шашныг Монголд дэлгэрүүлэхэд үлэмж хүчин зүтгэл гаргасан зүтгэлтэн бол анхдугаар буюу арванзургадугаар дүрийн Жибзундамба буюу Өндөр гэгээнтэн /1639-1723/ юм.

Тэрбээр нялх балчраасаа бурхны номд шимтэн суралцаж гоц гойд нь тодорсон учир 1639 онд Халхын лам ноёд Ширээт Цагаан нуурт чуулж, түүнийг

гэгээнтнээр өргөмжилж, Шарбүсийн орд гэгчийг түүний залрах өргөө болгон байгуулснаар Халх монголын бурхны шашны гол төв-Их хүрээний үүсгэл болжээ.

Үүний дараа тэрбээр 15 сүүдэртэйдээ Цастын оронд хүрч Рашилхүмбэ хийдэд дөрөвдүгээр дүрийн Банчин Эрдэнэд шавь орж улмаар Лхаст морилон Дээрхийн гэгээнтэнтэй багш шавийн барилдлагаа тогтоож түүнээс “Занабазар хутагт” цол шагнуулж гэлэнгийн санваар хүртээд 1651 онд Далай лам, Банчин Эрдэнэ хоёрын зарлигаар Түвдийн алдар суутай лам нар, уран дархан тавь гаруй хүнийг дагуулж Халх монголдоо эгэн морилсон байна. Занабазар хутагт монгол нутагтаа хэсэг хугацаанд байж шашин номын үйлс дэлгэрүүлээд 1655 онд дахин Түвдэд очиж хоёр жилийн дараа нутагтаа ирж 1691 он хүртэл халхын төв нутгуудаар Баруун хүрээ, Зүүнхүрээ зэрэг бурхны шашны хэд хэдэн төвүүдийг үүсгэн байгуулж дэг жаягийг нь боловсруулан дагаж шийтгүүлсэн байна. Энэхүү Занабазар хутагт буюу өндөр богдын дараах долоон дүр нь цөм Монгол газар бурхны шашны сургаал номлол дэлгэрүүлэн түгээхэд хувь нэмэр оруулцаасны дотор хамгийн сүүлчийн дүр нь /1869-1924/ 1874 оноос эхлэн таалал болох хүртлээ Монголд ялангуяа Халх буюу Гадаад Монголд бурхан шашныг тэтгэн дэлгэрүүлж бүх монгол овогтны дээдийн итгэл бишрэлийг хүлээж байлаа. Тэрбээр 1911-1919 онд Монголын шашин, төрийг хослон барьж байхдаа бурхны шашны хүрээ хийд, сүм, дуган, суварга, бурхан шүтээнийг цогцлоон бариулах, судар ном туурвих, орчуулах, барлуулах шашны дэг ёсыг чанд сахиулахад үлэмж хичээл зүтгэл гаргасан билээ. 1921-1924 онд түүнийг Монгол Улсын хэмжээт эрхт хаанаар өргөмжилснөөр тэрбээр шашны хамаг хэргийг дагнан эрхэлж хариуцаж байв.

VIII Богд Монголын шашин төрийн тэргүүн байхдаа зарлиг буулгаж эрдэмт лам, ноёд, түшмэдийг цуглуулан бэлтгүүлсэн” Монгол Улсын хууль зүйлийн бичиг” /65 дэвтэр/-ийн хэд хэдэн дэвтэрт Их шавийн ба тамга бүхий арван гурван хутагтын засаг захиргааны хуваарь, шашны ёслолын зан үйлийг чандлан зааж хутагт хувилгаадыг хэрхэн таньж тодруулах, тэдний шавь нарын тоо, эрхлэх албан тушаал, хариуцах үүрэг тэргүүтнийг тодорхойлон тусгажээ. Мөн эгэл лам, банди нарыг хэрхэн сургах, хэрэг зөрчил гаргаваас яаж шийтгэхийг хүртэл маш дэлгэрэнгүй зааж өгсөн байна.

Үүнээс гадна Манж Чин улсын үед Монгол нутагт шашны ямар нэгэн хүрээ, хийд, сүм дуган байгуулбал заавал Манжийн хаанаас нэр гуйж авдаг байсан журмыг уламжлан тус улсын аль ч газар сүм байгуулбаас Дотоод ямаар уламжлан Богд эзэн хаантны зарлигаар нэр шагнуулж байхын сацуу шагнан хайрласан нэрийг түвд, монгол үсгээр хичээнгүйлэн бичүүлж сүмийн хаалганы гадна өлгөх янфай, шөрөг, мориноос буух хөшөө байгуулж шарын шашныг хүндэтгэж байхыг заажээ.

Мөн тайж нар лам болохыг хүсвэл Дотоод яамнаа уламжлан мэдүүлж тусгай зөвшөөрөл авч байхыг энэхүү хуульд зааж өгсөн байна.

Анхдугаар дүрийн гэгээнтнээс гадна Халхын Зая бандида Лувсанпэрэнлэй, Ламын гэгээн Лувсанданзанчойжигжалсан, Ойрадын Заяа бандида Огторгуйн далай хэмээх Намхайжамц, Галданбошогт нар бүгд Цастын оронд очиж бурхны шашны номд шимтэн суралцаж, уугуул монголдоо ирж олон хүрээ хийдийн эх үүсвэрийг тавилцсан байна.

Ийнхүү XVI зууны сүүлчийн хагасаас Түмэдийн Алтангэгээн хан, Халхын Абатай хан нарын идэвх хичээл зүтгэлээр түвдийн шарын шашин Монголд хүчтэй түгэн дэлгэрэхдээ тогтсон дэг журамтай болж зан үйл гүйцэтгэхдээ түүнийгээ чанд мөрдөж байв.

Өөрөөр хэлбэл, шашны том хүрээ хийдээс эхлэн жалгын дуган буюу жилд зөвхөн дүйчин өдрүүдэд хурал хурдаг хуйтан хүртэл өөр өөрийн дэг жаягтай бөгөөд түүнийгээ ягштал мөрдөхийн сацуу төрөөс баталсан хуулийн заалтыг ер

зөрчихгүйгээр ёсчлон дагаж чанд мөрддөг байлаа. Түүнээс гадна шашны хурал ном тахилга шүтлэгийн аливаа байгууламжийг төрийн хуулиар хамгаалж ямар ч хүн гэмтээх эвдэх хэмхлэх зорилгоор хандаж болохгүйг нилээд эрт үеэс эхлэн тусгай хууль дүрмээр чанд хориглож байсан ажээ. Тухайлбал 1614 онд Түмэнхэн Сайн ноёны оролцоотой боловсруулан дагаж шийтгүүлсэн нэгэн цаазын бичигт хан хүн сүмийн барилгыг гэмтээхээр гар хүрвэл *“долоон хошуугаар нэхэх буй. Халх даяар нэхэн цээрлүүлнэ”*. Хэрэв эгэл харц хүн *“гар хүрвэл”* *“хар биеийг алах, харайх барайх хөрөнгийг авах буй”* /Х.Пэрлээ.1974.18/ гэж зааснаас үзвэл жирийн албат ардаас эхлээд аймаг захирсан хан буюу ер нь ямар ч хүн сүмийн барилга байгууламжийг санаатайгаар гэмтээх буюу гэмтээхийг оролдох аваас хүнд ялаар шийтгүүлдэг байжээ.

Энэ цааз эрхэмж бүрэн бүтнээрээ олдоогүй учир дуган, суварга бурхан шүтээнд буруу санаагаар халдсан буюу түүнийг эвдэх гэмтээхийг оролдсон хүнд ямар ял ногдуулж байсан нь тодорхойгүй байна.

Үүнээс гадна Монгол дахь шашны газруудын үндсэн нэгж болсон сүм байгуулахад заавал мөрдөх журам мөн нилээд дээр үеэс эхлэн хэрэгжиж байсан аж. Тиймээс ч 1627 онд Манжийн Абахай хааны үеэс эхлээд Энх-Амгалангийн 35 дугаар /1696/ он хүртэлх дал шахам жилийн хугацаанд боловсруулж 1789, 1811 онуудад нэмэн шинэчилсэн *“Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг”* хэмээх том хуулийн таван дэвтрийг нь бурхны шашны асуудалд зориулсан байна. Уг хуульд Гадаад монголын шашны тухай олон заалт бий. Тухайлбал, тавиас дээш өрх айл хандив өргөж сүм бариулбал ямар ч тохиолдолд Гадаад монголын төрийг засах явдлын яамаар уламжлан Манжийн эзэн хаанд айлтгаж нэр гуйн шагнуулж байхаар заасан байдаг. /Зарлигаар... 1989.772/. Харин цөөхөн буюу 50-иас доош тооны айл өрхийн хандив хөрөнгөөр босгосон сүм эсвэл жижиг дуган байгуулбал Манжийн хаанаас нэр гуйх шаардлагагүй байсан бололтой.

Манж ба Богд хаант Монгол Улсын үеийн хуулиудад шашны барилга байгууламжийн маяг, хэв загварын тухай ямар нэг заалт байдаггүй бөгөөд энэ нь хуулиар зохицуулах боломж хомс байсантай холбоотой бизээ.

Харин Хэвт ёсны тэргүүн онд буюу 1909 онд Түшээт хан, Сэцэн хан хоёр аймаг Их шавийн эрх мэдэлтнүүд хамтран боловсруулж Богд Жибзундамба хутагтад толилуулан хүрээнд сууж байсан манж сайдаар зөвшөөрүүлж хожим 1918 оны тавдугаар сарын 20-нд Богд хааны зарлигаар дагаж шийтгүүлсэн ***“Хүрээний зэрэг газрын лам нарын муу самуун явах зэрэг гажуу суртлыг цаазлахын учир”*** хэмээх нэртэй 32 зүйл бүхий дүрэмд шашны барилга байгууламжтай шууд холбогдох заалт байхгүй боловч шашны хүрээ хийд, аймаг, дацангийн тухай тодруулж болохуйц зүйл байгаа нь сонирхол татаж байна. Тухайлбал, Их хүрээ нь Гандан хүрээ, Зүүн хүрээ гэсэн хоёр хүрээтэй байсныг энэхүү дүрмээс мэдэж болно /Жинхэнэ.2004.179/. Хүрээний шашин номын хэргийг хамба номунхан удирддаг байлаа.

Үүнээс гадна Нийслэл хүрээнд сууж буй лам нар нь заавал дацан, аймагт захирагдах бөгөөд тэд нэг бол сургуульд суралцаж, эсвэл хуралд хурж байх ёстой. Харин төр шашны байгууллагад алба хаадаг лам нар хэрэв өөрсдөө хүсвэл зарим үед буюу дүйчин өдрүүдэд хурал хурах эрхтэй байжээ. Эдгээр гурван янзын лам нарыг ямар нэгэн хэрэгт сэжиглэн байцаах эсвэл хэрэг өдүүлсэн нь нотлогдсон лам нарт ял шийтгэл ногдуулахдаа заавал Нийслэл хүрээний эрдэнэ Шанзудба-д мэдэгдэж зөвшөөрөл авах журам тогтоожээ.

Нийслэл хүрээнд гучин аймаг арван дацан байсан ба аймаг хэмээх байгууламж анх 1651 онд үүссэн /Пүрэв.1994.24/ хэмээн олон судлаач бичсэн боловч аймаг нь дотроо ямар нэгжид хуваагдагийг түүхчид төдий л тодруулаагүй

бол дээр дурдсан 32 зүйл дүрэмд зааснаас үзэхэд аймаг нь арванд хуваагдана. Өөрөөр хэлбэл арван айлын хашааг нэг арван болгож тусгай дарга томилж шөнийн цагт харъяат арваныг манах цагдаа хоёр хүнийг арваны дарга томилно. Мөн арваны дарга нарын аль нэгийг томилж шөнийн харуул манаанд гарсан хүмүүсийн үйл ажиллагааг байцаан шалгуулдаг байжээ. /Жинхэнэ...2004.219/.

Дацангууд бол шашны ба засаг захиргааны хоёрдмол шинжтэй байлаа. Тиймээс ч дацангийн эрх мэдэлтнүүд "харъяат лам нартаа түр чөлөө олгох, зэмлэл шийтгэл ногдуулах" зэрэг олон ажил явдлыг удирдан зохицуулдаг байсан нь мөн энэ дүрмээс мэдэгдэж байна /Жинхэнэ...2004.253/. Гэвч дацан бүр нь өөрийн эрхлэх чиглэлийн дагууд тэргүүнийх нь албан тушаал шунлайв, доржловон тэргүүн лам, удаах нь гэсгүй унзад нар байжээ. Олон сүмийн тэргүүн ч мөн үүнтэй адил цорж лам, тэргүүн лам гэсэн хоёр янз байжээ /Зарлигаар. 1995.138,139/.

Сурвалж бичиг, судлаачдын бүтээлд хүрээ, хийд, аймаг, дацан, дуган, сүм, хуйтан, жас, суварга хэмээх нэрс олонтаа бичсэн байх боловч тэдгээр нь чухам ямар зориулалттай, хоорондоо ямар ялгаатайг тодруулан авч үзсэн бүтээл цөөн бололтой. Гэхдээ эдгээр нь харилцан адилгүй үүрэг бүхий шашны зан үйл гүйцэтгэх, сургалт эрхлэх, аж ахуй хариуцах байгууламжууд байсан нь мэдээж хэмээн хэт дөтчилэхгүйгээр тус бүрийнх нь тухай улируулан судлах нь зүйтэй. Ийм судалгаагүйгээр шашны тухай шинжилгээний чамбай бүтээл туурвих боломжгүй билээ. Иймээс энэ талаар цухас өгүүлье. Хүрээ гэдэг бол шашны хэд хэдэн хийд, сүм, аймаг, дацан, суварга бүхий томоохон байгууламж буюу суурин газар юм. Хүрээдийг гол төлөв хутагт хувилгаад юмуу засаг ба засаг бус ноёдын нэрээр дурдан тэмдэглэсэн нь олон байдаг. Жишээлбэл Эрдэнэ бандида хутагтын хүрээ Түшээтхан аймгийн Дайчин ван Ханддоржийн хүрээ гэх мэт. Эсвэл байрлаж буй газраар нь нэрлэдэг. Жишээ нь, Сайн ноён хан аймгийн Дуутын хүрээ гэх мэт.

1730-аад оны сүүлчээс эхлэн Монголын хүрээ хийдийн ихэнх нь суурьшмаг болж урьдын адил нүүдэллэх нь зогссоноор орон барилга олонтой болж хурдаг ном, тахидаг шүтээн нь ч олширч байжээ. Гэвч тэр үеийн хүрээ хийдүүдийн барилгыг гол төлөв модоор барьж байсан учир өнөө үед үлдэж хоцорсон нь ховордуу юм. Жишээлбэл, Мөрөнгийн хүрээ Жалханзын хүрээ зэрэг хэдэн зуун лам хуврагтай олон сүм дугантай байсан газруудын нэг ч барилга эдүгээ үлдэж хоцроогүй аж. Монголын томоохон хүрээ хийдүүд нилээд суурьшилтай байсан боловч XX зууны эхээр Ховд хязгаарт түр суурьшсан Ноён хутагт номунхан хэмээх Дамбийжанцан одоогийн Увс аймгийн нутагт байсан хэд хэдэн хүрээ хийдийг Мунжиг хэмээх газар хүчээр шилжүүлэн төвлөрүүлэхээр завдсаныг нутгийн лам нар сүсэгтэн олон эрс эсэргүүцсэний сацуу Богд эзэн хаан дэмжиж зарлиг буулгасан учир тэрхүү Дамбийжанцан санаархлаа биелүүлж чадаагүй байна. Хүрээ хийдийг шинэ газар шилжүүлэх нь олон талын сөрөг үр дагавартай нь хэн бүхэнд мэдээж учир ийнхүү тогтвор суурьшилтай байхыг хичээх нь зүйн хэрэг билээ.

Монголын хүрээ хийдүүд нийтдээ бурхны шашныг түгээн дэлгэрүүлэх сүсэгтэн олонд буян ном түгээх үндсэн зорилго агуулдгаараа ижил боловч зарим хүрээ хийд шашны бүтээл туурвилыг орчуулах, ном барлах, бурхан бүтээх талаараа бусдаас онцгой ялгарч байв. Жишээлбэл Сайн ноён хан аймгийн тамгатай хутагт чин сүжигт Номун ханы тавдугаар дүр Цэдэнбалжир өмнөх дүрүүдийнхээ нэгэн адил ном бүтээл туурвих барлах түгээхэд түлхүү анхаарч номын өглөгийг дээдэлдэг байв. Тус хутагтын хүрээний модон бар халх төдийгүй нийт Монгол даяар алдартай билээ. Хутагт Цэдэнбалжир өөрийн хүрээнд туурвисан ном судраа хамгийн цөөн гэхэд заавал гурван хувь барлаж нэгийг нь Богд эзэн хаанд, нөгөөг нь Сайн ноён ханд өргөж үлдсэнийг нь хүрээнийхээ номын өргөөнд хадгалдаг "хэв хууль"-ийг ямагт чанд мөрддөг байлаа.

Дашрамд тэмдэглэхэд, монголын бүх хүрээ хийдийн чухам хэд нь өөрийн бархан буюу хэвлэлийн тусгай газартай байсныг одоогоор нарийвчлан тогтоож чадаагүй учир цаашид тусгайлан судлах нь чухал байна.

Манай улсын нутагт байсан зарим хүрээ хийдэд алдарт хүмүүс, соёл, урлагийн нэн ховор дурсгалыг нэхэн шинжлэхэд эш тулгуур болохуйц зүйл цөөнгүй хадгалагдаж байжээ. Жишээлбэл Түшээтхан аймгийн Бэрээбэн гэжий гандан шаддублин хийд (Өвөрхангай шанхын хийд)-ийн нэгэн дуганд Чингис эзний цэргийн догшин хар сүлдийг тахиж байсан /Өвгөн Дэндэв. 1961.30/, Сэцэнхан аймгийн Бэрээвэн хийдэд "Чингис хааны сэлэм, эмээл найман зуун жилийн тэртээгээс хадгалагдаж байсан гэж Уйгарын нэгэн иргэн 1920-иод оны эхээр Нийслэл хүрээнд байхдаа сонссоноо өөрийн дуртгалд тэмдэглэжээ. (Ладислаус 1992.138)

Мөн зарим хүний сонссоноор бол Нийслэл хүрээний Голын цагаан сүм буюу Гунгаадэжидлин сүмд гангаар үйлдсэн үзүүр тохой хир өндөртэй Ямандаг бурхан байсан бөгөөд түүнийг сүүлчийн Богдын үед (1874 оноос хойш бололтой З.Л) Сайн ноён аймгийн Далай Чойнхор вангийн хошууны дархчууд урласан гэнэ. /Өвгөн.7/ Бас зарим хүрээ хийдүүдэд улс орны түүхтэй холбогдох олон үйл явдал болж өнгөрсөн байдаг. Жишээлбэл Нийслэл хүрээ, Ханддоржийн хүрээ, Заяын хүрээ, Сайн ноёны хүрээ болон одоогийн Баянхонгор аймагт буй Амарбуяантын хийдэд 1904-1906 онд Түвдийн төр шашны тэргүүн XIII Далай лам Түвдэнжамц морилон саатаж байсан ба түүнд зориулан үйлдсэн сүм Гандан хийд, Эрдэнэзууд бий. Үүнээс гадна Амарбаясгалант хийд, Дамбадаржаалин буюу шашныг бадруулагч хийд, Нийслэлийн хүрээний Гандантэгчинлэн хийдэд Монголын шарын шашны тэргүүн өндөр гэгээнтэн ба түүнээс хойшхи хэд хэдэн Богдын шарил чандрыг олон жил хадгалж байлаа. Гэвч 1930-аад оны дундуур хэсэг зуур цөвүүн цаг тохиосны уршгаар тэдгээр шарил чандрыг сүсэгтнүүд өөр газар шилжүүлэн байрлуулсан нь эдүгээ чухам хаана байгааг тун цөөхөн хүн мэдэх боловч болгоомжлох үүднээс хэн хүнд зааж өгөх тун дургүй ажээ.

Харин анхдугаар буюу XVI дүрийн Дээрхийн гэгээнтнийг төрүүлсэн эх Ханджамцын шарилын бунхан эдүгээ Эрдэнэзуу хийдэд бүрэн бүтнээрээ байх боловч улирах цагийн аясаар нилээд хуучирч нурж унахад тун ойртсон байгааг нэн даруй засах нь чухал боллоо. Энэхүү бунхан бол манай улсад байгаа монгол хатны шарил чандар агуулсан цорын ганц бунхан юм. Мөн зарим судлаачдын олж тогтоосноор бол 1673-1674 онд Өндөр гэгээнтэн ах дүүсийнхээ хамт эх Ханджамцынхаа дурсгалд зориулж, Хонсимбодисадвагийн сүм бариулсан ажээ. Гэвч хожмоо уг сүм хэрхсэн нь тодорхойгүй.

Харин манай улсын нутагт одоогоор мэдэгдээд байгаа шарилын нилээд том сүм гэвэл Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт буй Гүнжийн сүм юм. 1697 онд Манж Чин улсын Энх-Амгалан хаан өөрийнхөө гүнж (төрсөн охин)-ийг Халхын Түшээтхан аймгийн засаг Дархан чин ван Дондовдоржид хатан болгон шагнасан аж. Хожим тэрхүү гүнж таалал төгсөхөд Хан Хэнтийн Баруун Баян гэдэг аглаг их ойн бяцхан чөлөөнд тусгай сүм байгуулан түүний шарилыг оршуулж, улмаар 1740 онд гэрэлт чулуун хөшөө босгосон байна. /Дамдинсүрэн Ц. 1961.3-8/

Толь бичигт буддын сүм хийд /Sangharama/ бол хувраг шавь нарын оршин суух барилгыг ерөнхийлэн заасан нэр гэж тайлбарлажээ. Одоогийн ойлголтоор хийд гэдэг бол гол төлөв томоохон хүрээнд байх хэд хэдэн сүм дуган бүхий тусгай хэсэг юм. Жишээлбэл Нийслэл хүрээний Гандантэгчинлэн буюу Төгс баясгалант хийд гэх мэт.

Сүм бол бурхны шашны хувраг, шавь нарын ном хурах бясалгал хийх газар бөгөөд "олны хүрээлэн", "бурхны гэр" гэсэн утгатай санскрит үг ажээ. Гэвч монгол хэлэнд сүм дуган хэмээн хоршин нэрлэдэг. Сүм дуган бол гол төлөв хурал ном хурах газар боловч бурхны сүм, дуган тахилын сүм, шарилын сүм, маанийн дуган, ярнайн дуган, "догшидын дуган", шарилын дуган гэх мэт олон янзын зориулалттай

дуган байжээ. Ярнай (Summer residence of a monk) гэдэг нь зуны суудал гэсэн утгатай үг бөгөөд Энэтхэгийн бурхны шашны лам нар аагим халуунд хаашаа ч явахгүйгээр тусгай сүмд сууж гурван сар ном бясалгахыг хэлдэг. Шигмунийн үеэс үүссэн энэ ёсыг шарын шашны лам нар дагаж жил бүр зуны адаг сарын 15-наас намрын дунд сарын шинийн нэгэн хүртэл 45 хоног ярнайд сууж хурал хурдаг байжээ. Ярнайн гол уншлага нь арван зургаан ахуйн шүтээн ба Намсрай байв. Ярнайд сууж буй лам нар улаан цав-мах тос зооглож болдог байжээ.

Сурвалжид тэмдэглэснээр бол зөвхөн Нийслэл хүрээ ба хөдөөгийн томоохон хүрээ хийдэд байсан Буян-ерөөлт, Буяныг залбирагч, Өлзийхутаг ном дэлгэрэх, Чүлтэмжанзовлин, Өршөөлийг соёгч, Билэг Өлзийт, Сайныг бадруулагч, Түгээмэл ивээлт, Гайхамшигт тунхлагтай, Соёлыг ивээгч, Хотлыг гийгүүлэгч, Амгалант номын тив, Бодь их амгалант, Өрнөн дэлгэрүүлэгч, Дэжидчойлин, Жанцавдайчинлин, Өглөгийг бадруулсан, Өршөөн аврагч, Түгээмэл Өлзийт, Хотол барилдлагат, Дандаршаравжонпилин /Зарлигаар... 1995.1389-141/ зэрэг олон сүмийн мяндагтнууд /тэргүүн лам, цорж, гэсгүй, унзад, шунлайв, донир/-ын орон тоог Богд хааны зарлигаар баталсан төрийн хуульд маш тодорхой зааж өгсөн байдаг.

Гэтэл эдгээр сүм чухам хэзээ байгуулагдсан ба хаана байрлалтай байсан, ямар ямар шүтээнтэй хэд хичнээн ламтай хэдэн дуган, суварга жастай байсан зэрэг нь ер тодорхойгүй байгааг цаашид нэхэн судлах зайлшгүй хэрэгцээ байна.

Сүм нь ерөнхийдөө хурал хурах, бурхан шүтээн залан байрлуулдаг газар боловч дотроо бас нарийн зааг ялгаатай бөгөөд зарим нь хувь хүн буюу өндөр мяндаг зэрэгтэй хутагт хувилгаад номын багш нарын орд өргөө эсвэл тэдний бүтээлээ туурвих урлах зориулалттай байжээ. Монгол улсын нутагт олон сүм байсан боловч бусдаасаа илүү алдаршсан нь Эрдэнэ зуу хийдийн Зуугийн сүм, Их Хүрээний (1911 оны эцсээс Нийслэл хүрээний) Майдарын сүм, Арьяабалын сүм гурав байсан гэж Монголчууд ч ярьдаг, гадаадын зарим хүн ч мөн ингэж дурдсан байдаг. /Майский 351, 354/ Жич Монгол улсын нутагт байсан сүм хийдийн ихэнх нь буддын шашны шарын номлолыг шүтэж байсан бол хааяа зарим нь бусад чиглэлийг дээдэлдэг бөгөөд тэдгээр нь ямар нэгэн хавчлага хяхалтад төдий л өртдөггүй байжээ. Жишээлбэл Сэцэн хан аймгийн Хүүхэн хутагтын хүрээний гол сургаал номлол нь буддыг христиан болон магометан шашинтай эвлэрүүлэх чиглэл барихын хамт өөрийн номлол баримтлагчид эр эм бололцох хатуу зөөлөн ундаа хэрэглэх, иргэний амьдралын таашаал эдлэх зэргийг зөвшөөрдөг байжээ /Майский 352-т үз/. Мөн түүнчлэн Сэцэн хан аймгийн засаг хурц ван Түддэн 1919 оноос өмнө өөрийн хошуунд хөхийн шашны хурал гаргаж түүнд хамба лам, унзад, гэсгүй, зэрэг албан тушаалтан томилсоныг (Ардын 1960, 197) тус хошууны харьяат нар дургүйцэн заргалдсан байдаг. Мөн Сэцэн хан аймгийн бишрэлт засаг бэйс Пүрэвжав 1895 оны намар харьяат хошууныхаа ард олноос "гарамба (улаана) хийдийн хандивт өгөх" (Ардын 1961, 115) мөнгө татварлан хурааж байжээ.

Сурвалжаас үзвэл 1913 оны орчим Монголын Гадаад хэргийн яаманд Оросын Элчингээс бичиг өргөдөл гаргаж "манай харьяат Татар хэмээх хотын овгийн хүмүүс (мусульманыг хэлж буй бололтой З.Л) шашны сүм ба тэнхим сургууль байгуулах бяцхан газар олгоно уу" хэмээн хүссэнийг тус яам Богд эзэн хаантанд толилуулан айлтгахад "гуйсан ёсоор болгогтун" (Үндэсний АЗ-1-6 хуудас 15А) гэж зарлиг буулгасан байдаг. Харин уг сүмийг байгуулсан эсэхийг хэн ч тодруулаагүй бололтой. Үүнээс гадна Монголд цагаачлан сууж байсан харь үндэстний хүмүүс ч өөрсдийн шүтдэг шашны сүм, мөргөлийн газрыг зохих зөвшөөрөл авсны дагуу байгуулах эрхтэй байжээ. Жишээлбэл 1919 онд Монголд ирсэн нэгэн япон хүний бичсэнээр бол Нийслэл Хүрээний зүүн этгээдэд орших

лбэг амгалантад хятадын гэсэр сүм, хотонгуудын лалын сүм үйл ажиллагаа явуулж байжээ. (Алмаас Д. 1919 оны... тавдугаар нүүр)

Эдгээр баримт бол Монголын эрх баригчид буддизмыг төрийн шашин хэмээн дээдлэхдээ бусад шашныг ямар нэгэн байдлаар хяхан хавчиж үйл ажиллагааг нь хориглож байгаагүйн нотолгоо билээ.

Монголын олон хийдийн үндсэн хэсэг болсон сүмийн янз бүрийн бурхан шүтээний заримыг нь маш сонин үйл явдлаас сэдэвлэн бүтээж байжээ. Жишээлбэл Амарбаясгалант хийдийн Хажидын сүмд тахьдаг "улаан хажид" бурхныг бүтээхдээ өндөр богдын дотно танил уран цутгуурч бүсгүйн шарилыг чандарлахад шатаагүй үлдсэн баруун гарынх нь үнсийг бусад зүйлтэй хольж хийсэн хэмээх домог яриа байх бөгөөд үүнийг зарим хүн бодитой зүйл гэж ч үзэх нь бий /Өвгөн. 1959. 6/.

Монголын зарим сүм буюу хийд их асар хаалганыхаа өмнө этгээдэд ямпай хэмээх маш гоёмсог хэрэмтэй байжээ. Эдүгээ Улаанбаатарт буй Богдын ногоон орд, Чойжинламын сүмд ийм ямпай байсан нь бүрэн бүтнээрээ үлджээ. Үүнээс гадна Амарбаясгалант хийдэд ямпай байдгийг доктор Ж.Урангуагаас саяхан сонслоо.

Мөн зарим сүмийг барилгынх нь өнгөөр хөх сүм, цагаан сүм, шар сүм хэмээн нутгийнхан нэрлэдэг байсны улмаас тухайн сүмийн албаны ёсны нэрийг эгэл хүмүүс мэддэггүй байжээ. Жишээ нь Ховдын шар сүм, Голын цагаан сүм гэх мэт олонд алдартай нилээд сүм байв. Гэтэл цагаан сүмийг Гүнгаадэжидлин гэж нэртэй байсан ажээ. Тус сүмийг бас Доод сүм гэж ч ярьдаг байсан гэдэг. /Өвгөн 1959. 8/ Уул сум бол Богд Жибзундамба хааны зуны орд өргөө байжээ. Бас анхаарч үзүүштэй онцгой нэртэй сүм ч байсан билээ. Тухайлбал манай улсын дорнод хязгаарт Халхын сүм гэж байсан тухай олон сурвалжийн мэдээ бий. Гэтэл тэрхүү сүмийн талаар Сэцэнхан агсан Навааннэрингээс өөр хүн төдий л хөндөж үзээгүй бололтой байдаг.

Аймаг бол том хүрээний үндсэн нэгж юм. Жишээлбэл Нийслэл хүрээний 30 аймаг гэх мэт. Нэг аймагт хэдэн өрх хашаа, хүн хамрагдаж байсан нь тун тодорхойгүй. Харин гадаадын зарим эрдэмтний бичсэнээр бол Түгээмэл Элбэгтийн 5 дугаар /1855/ онд Их хүрээний нэг аймагт дунджаар 441 хүн, Эрдэнэ зуу хийдийн нэг аймагт 460 хүн байсан ажээ /Таяама. 228/. Ер нь Монгол Улсын нутагт байсан олон хүрээ тус бүрийн аймаг, дацанг нэг бүрчлэн тодорхойлж судалсан бүтээл тун ховор бололтой. Үүний гол шалтгаан нь Монголын шашны байгууллага-төвүүдийн тухай судалгаа шинжилгээ хомсхон байгаатай шууд холбоотой юм.

Үүнээс гадна томоохон хүрээ хийдүүдэд хэд хичнээн тооны ямар нэртэй суварга байсныг ч нарийвчлан судалсан бүтээл одоо хир үгүй байна. Суварга гэдэг бол шашны ёсны дурсгалын шүтээн юм. Суварга нь төрлийн хувьд олон янз бөгөөд тахилын, шарилын, дурсгалын суварга зонхилж байдаг бол зарим тохиолдолд буруу тэрсүүдийг номтгосон газарт ч бас суварга босгодог байжээ. Жишээ нь одоогийн Баянхонгор аймагт алмас дарж устгаад сэг зэмийг нь булсан нүхэн дээр нь босгосон суварга хориод жилийн өмнө бүтнээрээ байсныг сэтгүүлч Х.Цэвлээ бичсэн байдаг. Жич тэмдэглэхэд сүсэгтэн олон хамгийн их буян хураахын тулд арван хар нүглийг чанд цээрлэхийн сацуу бурхан шүтээнд өргөл лам хуврагт өглөг өргөж бурхан, маанийн хүрд, номын бар, суварга бүтээж байжээ. Гэвч хүрд, бар, суварга, бүтээхэд бага бус бэл бэнчин хэрэгтэй учир сүсэгтнүүд ганцаараа болон дамжаа, зиндаа, өрх гэр, айл саахалт, аймаг, хошуугаараа эвсэж хамжин хөрөнгө цуглуулж суварга бүтээлгэсэн тухай аман болоод бичгийн сурвалж цөөн бус бий. Жишээлбэл эдүгээгийн Хөвсгөл аймгийн

Жаргалант сумын төвийн ойролцоо Гэлэнхүүгийн бүтээсэн суварга гэж бий. Гэвч Гэлэнхүүгийн тухай бичгийн сурвалжаар нэхэн тодруулаагүй байна.

Мөн зарим баримтад дурдсанаар бол Монголын төрийн тэргүүн, ерөнхий сайд агсан эрдэмтэн түүхч А.Амар 1928 оноос өмнө Дайчин вангийн хүрээ буюу одоогийн Булган аймгийн төвд “хорин хэдэн мянган төгрөгийн алтан суварга байгуулж байсан”. (МАХН-аас 1931, 9) гэнэ. Мэдээжээр энэ нь алтадмал суварга байсан буй за. 1931 онд П.Гэндэнгийн илтгэлд ингэж дурдсан нь үнэн эсэхийг Булганы ахмад настнууд, түүхчдээс сураглаж тодруулахад зарим нь сайн мэдэхгүй ганц нэг нь ийм яриа байдаг хэмээн хариулж байв. Харин академич Ж.Болдбаатараас асуухад Амар абугай тийм алтан суварга бүтээлгэсэн нь үнэн гэнэлээ гэж хэлсэн юм. Иймд үүнийг цаашид сайтар нягтлууштай. Энэ дашрамд тэмдэглэхэд 1923 онд ерөнхий сайд С.Дамдинбазарыг таалал төгссөний дараа түүний шарилыг уул нутагт нь тусгай суварганд залж оршуулах саналыг А.Амар, С.Довчин, Н.Жадамба зэрэг арваад хүн хоорондоо ярьж тохирсон сурвалж баримт байдаг. Үүнээс үзвэл А.Амар үнэхээр бурхан шашин, хутагт хувилгаадыг дээдлэн шүтдэг байсан бололтой.

Мөн бурхны шашны хийдүүдийн зарим нь хашааныхаа дотор баруун хойд өнцөгт эсвэл гадна талдаа орон хийдийнхээ түүхийг монгол, манж, түвд, хятад хэлээр хураангуй бичсэн гэрэлт чулуун хөшөөтэй байсны нилээд нь эдүгээ бүтэн үлджээ. Жишээлбэл Цогт тайжийн Цагаан байшин, Дамбадаржаалин, Эрдэнэ зуу, Ховдын Шар сүм, Гүнжийн шарилын сүмийн хөшөөнүүд бараг хэвээрээ бий.

Шашны газруудын бүтцэд багтаж байсан боловч нэр нь эдүгээ монгол ярианы үгийн сангаас бараг хасагдсан байгаа хуйтан хэмээх нэрийн тухай цухас дурдах нь илүүц бус билээ. Хуйтан гэдэг бол зөвхөн дүйчин өдрүүдэд цөөхөн лам цуглаж тодорхой хэдэн ном хурдаг, лус дэлхий тахих зэрэг ёслол үйлддэг хурлын газар байжээ. Монгол үгийн тольд хуйтан гэдэг үг байхгүй боловч “хуй хурал” /Шагж. 1998.401/ гэдэг нь “сүм хийд ба айл хөдөөд боловч лам хуврагууд хуран цуглаж ном уншихыг хуй хурал хэмээмүй” /Хорин наймт.1994.979/ гэж эрдэмтэд тайлбарлажээ.

Эрдэмтэн багш С.Пүрэвжав “жигжиг хурлын газар буюу хуйтан” /С.Пүрэвжав.1978.135/ гэж тодорхойлсон байна. Мөн түүхэн газар зүй судлаач эрдэмтэн О.Пүрэв 2004 онд туурвисан “XX зууны эхэн үеийн Ар Монгол 1900-1930 он” хэмээх газрын зураг /карта/-таа одоогийн Говь-Алтай аймгийн Цээл суманд Хулстайн хуйтан гэж байсныг тэмдэглэсэн байна.

Бурхны шашны хурал номын газруудын төрөл, тэдгээрийн ялгааны тухай өгүүлэхэд ийм байна. Гэтэл манай улсад хичнээн хүрээ хийд, аймаг, дацан, сүм, дуган, суварга, гэрэлт хөшөө, ямпай байсныг ойролцоогоор гаргасан мэдээ тун бүдэг байна. Ялангуяа сүм хийдийн үнэн зөв тоо ховор бололтой. Жишээлбэл: 1921 онд И.Майскийн хэвлүүлсэн нэгэн бүтээлд Автономит гадаад Монголын сүм хийдийн тоог халх дөрвөн аймаг, Нийслэл хүрээг хамруулан тусгай хүснэгтээр хавсаргасныг бага зэргээр хураангуйлан үзүүлбэл:

№	Аймгийн нэр	Бүх сүм хийдийн тоо	Үүнээс	
			Засаг ноёдын	Тамгатай хутагтын
1	Түшээт хан (хошуу 20)	702	702	=
2	Сэцэнхан (хошуу 23, Тамгатай хутагт 2)	886	849	37
3	Засагт хан (хошуу 20, Тамгатай хутагт 3)	377	336	41
4	Сайн ноён хан (хошуу 24,	680	594	86

	Тамгатай хутагт 8)			
5	Нийслэл хүрээ	2		
6	Ховд хязгаарын Баяд, Дөрвөд, Мянгад, Өөлэд, Захчин	15	15	=
7	Хөвсгөл (Дархад) дахь Богдын шавь	90	=	90
	Бүгд	2752	2496	256

Энэ хүснэгтээс үзвэл И.Майский уул бүтээлдээ (*Майский И. Хавсралтын 26-30*) Халхын дөрвөн аймгийн Ховд хязгаар, Дархад, шавь, Нийслэл хүрээний сүм хийдийн тоог бүрэн гүйцэд авсан эсэх нь тодорхойгүй. Түүний номд Түшээтхан аймгийн Илдэн засгийн хошууны сүм хийдийн тоог орхисон байв. Бас Нийслэл хүрээний бүх хийд хоёр гэж тэмдэглэсэн атлаа тэдгээрт хамаарах сүм дуганы тоог орхисон байлаа. Харин Майскийн тэмдэглэсэн эдгээр тоог үнэн бодитой гэж үзэх аваас 1938 оноос өмнө эдүгээгийн монгол нутагт 2752 сүм хийд байсан нь лавтай. Өөр нэгэн судлаачийн тодруулснаар бол 1924 оны тоо бүртгэлээр манай улсад 113000 лам бүхий 600 орчим том хүрээ хийд, 1000 гаруй жижиг хурлын газрууд буюу дуган байжээ */Пүрэвжав. 1961.3/*. Энэ хоёр эрдэмтний бүтээлд дурдсан тоог харьцуулахад нэг мянга гаруйгаар зөрж байна. Иймд 1938 онд шашныг хориглохоос өмнө манай улсын нутаг дэвсгэрт хэдэн сүм хийд буюу хурал номын газар байсныг тун нухацтай нэхэн судлах зайлшгүй хэрэгтэй байгааг зориуд тэмдэглэе. Тэгэхдээ яагаад энэ талаар судалгаа хийх хэрэгцээтэй вэ гэдгийг тайлбарлах нь илүүц билээ

Шашны хурал номын газруудад шууд харъяалагддаг бас нэг нэгж бол жас юм. Жас нь гол төлөв сүм, аймаг, дацанд сүсэгтний өргөсөн хандиваар эх үүсвэр болгон байгуулсан аж ахуйн газар байв. Жасыг цогчин жас */Цогчин буюу гол сүмийн жас/* ердийн сүм, дацан, аймгийн жасыг ямар нэгэн тодотголгүйгээр Жас буюу зарим тохиолдолд Жас жав хэмээн нэрлэсэн нь ч байдаг.

Харин зарим хүрээ хийд нь аймаг дацан гэж хуваагдахгүй хэд хэдэн жастай байлаа. Тухайлбал эдүгээгийн Дорноговь аймагт байсан Чойрын хүрээ буюу Зүүн Чойрын хийд дотроо Баруун Чойр, Шарнууд ламримын хүрээ, Нарутын хүрээ, Чойрын ламримын хүрээ, Дүншигийн хүрээ гэсэн хэдэн жижиг хүрээ, арван таван сум дугантай байжээ. Мөн тус хүрээнд аймаг дацан гэсэн нэгж байхгүй, харин Цанид, Жүд, Дүйнхор, Мамба гэсэн дөрвөн жастай бөгөөд тэдгээр нь бусад хүрээ хийдэд байдаг дацантай ижил үйл ажиллагаа эрхэлж байсан бололтой. Ер нь энэхүү Зүүн Чойрын сүм монголын бусад хүрээ хийдээс ялгарахуйц хэд хэдэн онцлогтой бөгөөд харь хошууны харьяат лам тэнд ном хурахыг чанд хориглоно. Бас хятад хүн сүмийн горлом буюу хашаанд орж болохгүй. Хэрэв орвол сүм, дуганд шагайх орохыг огтхон ч зөвшөөрдөггүй. Лам хуврагууд тансаг зүйл эдлэх, хэт гоё хувцас өмсөхийг төдий л таашаадаггүйн сацуу бусад хүрээ хийдийн адил лам хүн архи уухыг үүрд хориглосон байжээ */Позднеев. 1898.607/*.

Мөн хааяа хөдөө хээр буюу хүрээ хийдээс алсхан байгуулсан нэг бяцхан байшин буюу гэр дугантай цөөхөн лам бүхий хурлын газрыг Жас гэж бас нэрлэдэг байжээ. Жишээлбэл, Цахиуртайн жас, Билүүтийн жас, Үнээн усны жас, Хангинахын жас, Элсэн Хонхорын жас гэх мэт олон жасын нэр янз бүрийн сурвалжид элбэг тохиолддог.

Жасууд нь сүсэгтний өргөсөн мал, эд хогшил, алт, мөнгө, шүр, сувд зэрэг эрдэнэсийг арвижуулж бүх өмчөө "арвин сан" буюу дотоод сан, "бадрах сан" буюу гадаад сан гэсэн хоёр санд хувааж байжээ. Арвин сан нь үндсэндээ жасын үл хөдлөх бүх хөрөнгө */бурхан, шүтээн, алт эрдэнэс, тэрэг чарга зэрэг малын тоног хэрэгсэл/* хамаарч байжээ.

Харин тухайн жасын мал сүрэг, мөнгөн тэмдэгт янз бүрийн цайг бадрах санд хамруулж ямагт өсгөн үржүүлэх арвижуулахад зориулахын сацуу өмчийн эзэн болох аймаг, дацан, сүмийн хэрэгцээт бүх хүнсийг байнга хангах үүрэгтэй. Жасыг нярав удирддаг бөгөөд жасууд өөрийнхөө малыг найдвартай буюу хөрөнгийн баталгаатай ажилсаг хүнд тодорхой болзолтойгоор түрээслүүлэн адгуулуулдаг. Бас тодорхой тооны малыг аймаг, сүм, дацангийн ойролцоо адгуулж өдөр тутмын хэрэгцээт сүү, шар тос, айраг, аарц, шүүс (мах)-ийг залгуулж байжээ.

Жасын мал адгуулж буй хүн өөрийн хариуцаж авсан малаа цааш нь өөр хүнд бас түрээсэлж болдог байснаараа нилээд онцлогтой. Өөрөөр хэлбэл Монголын сүм, хийд, аймаг, дацан, хуйтангийн жасууд дам түрээс буюу subarendag хориглодоггүй зөвхөн анхны түрээслэгчээ найдвартай хүнээр сонгож авахад онцгой анхаардаг байжээ. Иймээс ч жасын мал түрээслэгч хүн анх тохиролцсон болзлоо ямар ч тохиолдолд заавал биелүүлэх ёстой учир тэрбээр түрээсэлж авсан малаа өөрөө маллах уу эсвэл бусдад дамжуулж өгөөд бие амар сууж завсраас нь ашиг олох уу гэдэг нь жасад ер хүртээлгүй байжээ.

Жасууд аж ахуй эрхэлж тодорхой байгууламжийг хүнс хэрэгслэлээр тасралтгүй хангах үүрэг хүлээнснээрээ аймаг дацангаа өөр үүрэгтэй. Мөн үүнээс гадна жасыг түр хугацаагаар байгуулж татан буулгаж болдог. Жишээлбэл шинээр сүм барих суварга бурхан бүтээхэд зориулж жас байгуулж төлөвлөсөн зүйлээ дуусмагц жасаа тараадаг тохиолдол цөөнгүй байсан нь сурвалжид элбэг бий. Мөн аль нэгэн хийд буюу аймаг дацан сүмийн харъяат лам нарын зэд погийг тасралтгүй хангах үүрэгтэй тусгай жас ч бас байжээ.

Жас нь мал, хадлан тарианы газраас гадна цэвэр цагаан мөнгө, мөнгөн тэмдэгт, янз бүрийн цайг нилээд өндөр хүүтэй түрээслэж багагүй ашиг олж байв. Мөн зарим жас зөвхөн мал дагнах эсвэл аян жинг голлон эрхэлж ашиг орлогоо арвижуулж байлаа. Манж Дайчин улсын үед жасын бусдад түрээсэлсэн тарианы газрын орлогоос ямар ч татвар гувчуур огт авдаггүй байсан бол 1913 оноос эхлэн бүх жасын цэвэр ашгаас зохих хэмжээний татвар авах шийдвэр гарч /*Үндэсний төв. 13-1-445. 43-р нугалбар*/. 1938 онд шашны бүх байгууллага хаагдах хүртэл жас болон лам нарын татварын хэмжээг байнга нэмж байжээ. Ер нь энэ дашрамд тэмдэглэхэд жасууд аж ахуйгаа хэрхэн эрхэлж байсныг нэхэн судалбал нилээд сонирхолтой бүтээл туурвих боломжтой.

Монгол Улсын нутагт байсан шашны газрууд буюу хүрээ, хийд, сүм, аймаг, дацан, дуган, хуйтан, суварга, жасын тухай хураангуй өгүүлэхэд ийм буюу.

Эцэст нь тэмдэглэхэд, эдүгээгийн Монгол нутагт бурхны шашин түгэн элгэрснээс хойш олон жил улирсан авч судлаачид энэ талаар нэхэн шинжилж дорвитой бүтээл туурвиж амжаагүй байгаа нь зохих учир шалтгаантай билээ. Түүх нийгмийн ухааны судалгаа хийхэд ямар ч хориг саад байхгүй болсон 1990 оноос хойш зарим хүмүүс монголд буддизм нэвтэрч түгсэн тухай асуудлыг бага багаар хөндөж буй боловч цаашид гүнзгийрүүлэх зайлшгүй хэрэгцээ байгааг түүхийн судалгаа эрхэлсэн байгууллага-Монгол Улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэн, их дээд сургуулиудын холбогдох тэнхмүүд, шашны хурал номын газрууд, эрдэмтэд тодорхой зүйл сэдэж хэрэгжүүлэх талаар нэн хичээнгүйлэх цаг нэгэнт болжээ.

Abstract In this writing, how Buddhism first started to spread in the country of present Mongolia, its structures to carry out formal ceremonies, or the different aspects of monasteries, temples, study centers, tribes, and stupas, and monastic roperty-monastic livelihood were discussed.

Ном зүй

1. Алмаас Д. 1919 оны Хүрээ хот. (Япон худалдаачны тэмдэглэлээс) "Улаанбаатар" сонин 1994" 10"15; №193 (652)
2. Ардын заргын бичиг (XVIII"XX зууны эхэн) эмхтгэн боловсруулсан Ц.Насанбалжир, Ш.Нацагдорж УБ 1961
3. Дамдинсүрэн Ц. Гүнжийн сүм 1961
4. Дарма гүүш Алтан хүрдэн мянган хигээст. УБ.2006
5. Жинхэнэ дагаж явах хууль дүрэм. 1913"1918. эх бичгийн судалгаа. УБ.2004
6. Зарлигаар тогтоосон Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг.Хөлөн Буйр. 1989
7. Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг. УБ. 1995
8. Козлов П.К. Тибет и Далай лама. М.2004
9. Ладислаус форбат. Өргөө дэх цуст хядлага Иззофеф Гелетагийн өдрийн тэмэглэлээр бичжээ. Герман хэлнээс орчуулсан Гонгор Д.УБ 1992
10. Майский И. Орчин үеийн Монгол(Автономи Монгол XX зууны гараан дээр) Орчуулсан Ц.Отгон УБ 2001
11. МАХН"аас мөн намын долоодугаар их хурал хүртэл барууны аюултай тэмцсэн тэмцлийн тухай. Хоёрдугаар дэвтэр. 1931 оны тавдугаар сарын 16"нд Улаанбаатар хотын нам, эвлэлийн бүх гишүүдийн хурал дээр Намын төв хорооны нарын бичгийн дарга П.Гэндэнгийн тавьсан илтгэл. УБ 1931
12. Монгол үндэстний нэвтэрхий түүх. Бээжин. 1995
13. Нацагдорж Ш. Сүм, хамжлага шавь ард. УБ.1972
14. Өвгөн Дэндэвийн дурдатгал. Д.Наваан тэмдэглэн бичив. УБ. 1961
15. Өвгөн Жамбалын яриа. Ц.Дамдинсүрэн тэмдэглэв. УБ.1959
16. Позднеев А.М.Монголия и Монголы том I. Дневникъ маршрутъ. 1893 года. СП б.1898
17. Пүрэв.О. Монголын улс төрийн төв. УБ.1994
18. Пүрэвжав С.Монгол дахь шарын шашны хураангуй түүх. УБ.1978
19. Пүрэвжав С. Хувьсгалын өмнөх их хүрээ. Түүх эдийн засгийн найруулал УБ. 1961
20. Пэрлээ Х. Халхын шинээр олдсон цааз"эрхэмжийн дурсгалт бичигт. Монгол ба Төв Азийн орнуудын соёлын түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг. Tomus.VI.1"2. УБ.1974
21. Содбилиг. Шашны толь. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1996
22. Таяама Шигейрү. Чин улсын үе дэх монголчуудын нийгмийн байгуулал. Япон хэлнээс монголчилсон Баяндэлгэр. Хөлөн Буйр 1988.
23. Үндэсний төв архив
24. Хориннаймт тайлбар толь.Намжилмаа эмхлэв. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 1994
25. Шагж. Монгол үгийн тайлбар толь. Эрэхүйеэ хялбар болгосон чандманийн эрх. Бээжин. 1998